

ИШБАЛЖИРЫН “РАШААНЫ ХУРИМ” СУДРЫН ДОТОРХ ӨВЧНИЙ АНГИЛАЛ, НЭРСИЙГ ТОДРУУЛАХ НЬ

*Г.Мөнгөнтуяа¹, Г.Энхжин¹, Т. Цэцэгдарь¹, Ш.Болд¹, О.Шагдар²

¹ЭЗШУИС, ²АШУҮИС, Мэргэжил Дээшлүүлэх Институт

*Munguntuya.np39@gmail.com, Утас:88096416

DETERMINING OF DISEASE CLASSIFICATION AND NAMES INSIDE THE SCRIPTURE “WEDDING OF SPRINGS” OF ISHBALJIR

*Munguntuya G¹, Enkhjin G¹, Tsetsegdari T¹, Bold Sh¹

¹Mongolian University of Pharmaceutical Sciences

²MNUMS, Institute of Professional Development

*Munguntuya.np39@gmail.com, Phone:88096416

ABSTRACT

Introduction:

Traditional medicine of Mongolia, which is one of the intellectual and physical cultural heritage to Mongols, has been developing a knowledge-based traditional medicine system by intensifying the policy of training traditional medicine personnel with an optimal combination of evidence-based analysis, training and retraining of doctors.

Sumbe Khamba Ishbaljir (1704-1788), a well-known scholar of tradition, wrote in details about the causes and conditions of cold and hot crisis reactions, based on his own medical experiences. In addition, there are many examples of how Mongolian doctors adapted the treatment methods used in Indian and Tibetan medicines to treat their people making some changes to the medical herbs for extreme climate conditions.

We have chosen this topic for further studies and learn about additional facts from the scripture “The Spring Wedding” written by Sumbe Archbishop Ishbaljir for more public uses.

Methods:

1. Source research
2. Culture and anthropology
3. Analysis synthesis

Conclusion:

“Rashaani khurim” consist of five chapters. First chapter: The 6 main disease. They are wind, bile, phlegm, blood, serious fluid and bacteria. Second chapter: Fever, cold disease, vomiting, diarrhea, small pox, abdominal craps, bacteria, defect of fever and cold, combine wind with fever, disagree fever to cold are most important 10 disease. Third chapter: 70 disorders are caused by internal conditions. Male and female genital disorder, pediatric disorders and geriatrics. Fourth chapter: 19 disorders are caused by external conditions and trauma. Fifth chapter: There became 12 diseases classified by age and sex. The last 3 chapters classified to 101 disorders.

Key words: *Ishbaljir, fever, cold disease, main 6 disease*

Үндэслэл

Анагаахын шинжлэх ухааны мэдлэгнийг мийн хөгжлийн дагуу хурдтай шинэчлэгдэж байгаад мэдрэмжтэй хандаж, дотоод болон гадаадад оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх нь хүн амын эрүүл мэнд, улс орны хөгжилд ихээхэн нөлөөтэй юм. Ялангуяа өөр ямар ч үндэстэнд байдаггүй монголчуудын оюуны болон эдийн соёлын өвийн нэг Монголын уламжлалт анагаах ухааны салбар бүрт уламжлал, шинэчлэлийг оновчтой хослуулан, уламжлалт анагаах ухааны боловсон хүчин бэлтгэх бодлого, сургалтын хөтөлбөрийг тулхтай мэдлэг, нотолгоонд суурилан шинэчилж, эмч нарыг чадваржуулах, давтан сургах ажлыг эрчимжүүлж улмаар мэдлэгт түшиглэсэн уламжлалт анагаах ухааны тогтолцоог хөгжүүлэх нь чухал байна.

ХҮI зууны сүүл үеэс Аюурведээс эхтэй анагаах ухааны ном судрыг орчуулах төдийгүй монголын эрдэмтэй лам эмч оточ нар Энэтхэг, Төвөдийн эмнэлгийн ном зохиолыг өөрийн орны ахуй нөхцөл, уур амьсгал, орон нутгийнхаа эмт бодисын чанар байдалд нийцүүлэн монголын онцлогтой эм эмнэлэг, эмийн жорыг шинэчлэн боловсруулах ажлыг өөрийнхөө хөрсөнд буулгаж чадсан Монголын уламжлалт анагаах ухааны энэ үйлс бүтээлт үе үеийн эмч, оточ нар үлэмж их гавьяа зүтгэл гаргасныг тодруулах нь чухал юм¹. ХҮII зууны үеэс эхлэн монгол эмч нарын туурвисан бүтээлд үндсэн онол болон эмчилгээний эл салааг багтаасан тусгай зохиол болох “Дөрвөн рашаан”, эмийн судлалын тусгай зохиол “Үзэсгэлэнт нүдэн чимэг” эм найрлагын ухааны тусгай зохиол “Эрдэнийн сан” (Увдисын далай) зэргийг дурдаж болно. Үүнээс гадна эмт бодисыг зөв таних арга ухаан, эмийн түүхий эдийн хоруу чанарыг гаргах буюу номхотголын арга, өвчний

1 Болд Ш. Монголын анагаах ухааны түүх. Улаанбаатар, Адмон ХҮ, 2006, х.248

мөн чанарыг оновчтой оношилон тогтоох эмчийн туршлага, газар газрын эмч нарын өөр өөрийн овор төрхийг хадгалсан жорын судар эмчилгээний бас бус арга туршлага энэ бүхэн нийлээд Монгол анагаах ухааны шинж чанарыг агуулсан нэгэн цогц бүтээл болдог юм. Энэ бүхнээс Монгол анагаах ухааны онол, эмчилгээний арга туршлага бүрэлдэн гарсан гэж хэлж болно.²

Монголын нэрт эрдэмтэн Сүмбэ Хамба Ишбалжир (1704-1788) “Дөрвөн рашаан” хэмээх зохиолдоо хүйтэн өвчний үүсэх шалтгаан, нөхцөл, халуун, хүйтний хямрал түүний урвах чанарын талаар өөрийн эмчилгээний туршлагадаа тулгуурлан дэлгэрэнгүй бичжээ. Ингэж Энэтхэг, Төвөдийн анагаах ухааны онол, эмчилгээний арга туршлагыг монгол эмч нар өөрийн орны цаг уур, ахуй нөхцөл, хүн ардынхаа бие махбодын онцлогт нийцүүлэн эмийн хөл, хачир тэргүүтэнд өөрчлөлт оруулсан жишээ цөөнгүй бий.

Иймд бид Сүмбэ хамба Ишбалжирын зохиосон “Рашааны хурим” судрын эх сурвалж, баримтуудыг судлан судалгааны эргэлтэнд оруулах, олны хүртээл болгохоор энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго

Сүмбэ хамба Ишбалжирын “Рашааны хурим” судрын доторх өвчний ангилал, нэрсийг тодруулах

Судалгааны арга

1. Эх бичиг, сурвалж бичгийн судалгааны арга
2. Соёл хүн судлалаар шинжлэх арга
3. Анализ, синтезийн арга

2 Болд Ш. Монголын анагаах ухааны парадигмын шилжилт (XVIII-XIX зуун хүртэл). Монголын анагаах ухаан, 2008, 3(145)

Судалгааны үр дүн

Сүмбэ хамба Ишбалжирийн “Дөрвөн рашаан” судар бол УАУ-ы сонгодог гол судруудын нэг бөгөөд “Дөрвөн үндэс”-ийн тайлбар зохиол юм. “Дөрвөн рашаан” судрыг төвөд хэлээр хэвлүүлжээ.

Сүмбэ хамбын өөрийн нь бичсэн намтар болох “Дуун баригчийн тэжээл” үндэслэвэл тэрээр Хөхнуур мужийн Толь гацаа /Хатан голын хөвөө нь дэх/-ны хүн юм. 1704 он (12 дугаар аливжингийн хөх бичин жил, Энх-Амгалангийн 43 дугаар он) билгийн улирлын 8 сарын 15 –ны өглөө луу цагт Ойрд аймгийн Батуд овгийн тайж Дорждашийн 4 дүгээр хүү болон төржээ. Ээж нь Ойрад монголын зүүн гарын Дашцоо гэдэг хүн байжээ.



Сүмбэ хамба Ишбалжир

Зураг 1. Сүмбэ Хамба Ишбалжир

1707 он (улаагчин гахай жил, Энх-Амгалангийн 46 дугаар он)-д 4 настайдаа Жанжаа хутагт Агваанлуvsанчойдонгоос түүнийг Гонлун хийдийн Сүмбэ шавдрун Лувсандамбийжалцангийн хувилгаанаар тодруулжээ.

Сүмбэ хамбын талаар дотоод, гадаадын монголч эрдэмтэд анхаарал тавьж багагүй бүтээлүүд нийтлүүлсэн ч энэ нь ихэнхдээ

уран зохиол, түүхийн талаархи ажлууд нь хамрагдаж байжээ. Ялангуяа МУИС-ийн профессор зурхайч Тэрбиш багш Ишбалжирын зурхайн талын бүтээлийг нарийн судалж өөрийн эрдмийн ажилдаа дурьдсан байна. Ишбалжир залуу наснаасаа орон нутагтаа болон Төвөд оронд очиж анагаах ухаанд суралцаад анагаах ухааныг эзэмшихийн хамт Төвөд, Энэтхэгийн сонгодог зохиолд нэвтэрсэн мэдлэг, дадлагын явцдаа монгол оронд зонхилон тохиолддог өвчнийг анагаах ихээхэн туршлагыг хуримтлуулсан байна. Ялангуяа түүний бичсэн анагаах ухааны 5 иж бүрэн зохиол нь Монгол эмнэлгийг Төвөдийн “Дөрвөн үндэс”-ийн онол лугаа бүтээлчээр уялдуулж энэтхэг, төвөдийн анагаах ухааны туршлагыг монгол орны уур амьсгал хийгээд монгол үндэсний бие махбод аж амьдралын орчинтой уялдуулж бодитойгоор судалсан бүтээл юм. Иймээс эдгээр номууд монгол хөрсөнд бууж чадсан, онолын хувьд цоо шинэ санаа, эмчилгээний аргуудыг нээж өгснөөрөө гавъяатай.

Сүмбэ хамба Ишбалжир “Рашааны хурим” бүтээлийнхээ эхлэлийн хэсэгт:

Манал бурхан дор мөргөм үү.

Сайн үйлийн боловсролын үрээр эрдэнэт хүмүүний биеийг ологсодыг өвчингүй урт наслуулах, амгалан жаргалан уг чанар лугаа барилдуулах хийгээд дээдийн номыг төгсгөхийн тухайд бие хийгээд өвчнийг анагаан үйлдэх ухааны оронд болбоос ялгуусан винай, дүйнхор тэргүүтэн хийгээд хутагт Лүдэвийн “Зуун найрлагат”, Ловон Баавуугийн “Эм заслын найман гишүүнт”, түүний их тайлбар “Наран гэрэл” тэргүүтнийг номлосон бөгөөд тэдгээрийн утгыг хураангуйлаж цастын оронд язгуур, номлол, увдис, хойд хэмээн алдаршсан дөрвөн үндэс үүссэн бөлгөө.

Би бээр түүний бага гурван үндсийг

хураангуйлан эх шүн буюу “Рашааны ундрал” хийгээд увдисын үндэсний утгыг хураангуйлан гарын авлагын хөвгүүн шүн буюу “Рашааны цагаан шүүдэр”, мөн дахин хурааж “Рашааны дусал” тэргүүтнийг зохиосон билээ. Тэр мэт бас оюун бага, хичээнгүйгээр дутмаг, олз өчүүхэн эмч нарт зориулан машид цөөлөн хураасан чухал хэрэгцээт “Рашааны хурим”-ыг зохиовой” хэмээн Рашааны хурим судрын эхэнд бичсэн бол “Эм, заслыг машид цөөлөн хураасан рашааны хурим” хэмээх үүнийг Шагжагийн Тойн Сүмба Хамба 81 насандаа усан туулай жил хоёрдугаар оточ Ётог Юндонгомбын зохиосон олон увдисуудыг түүвэрлэн зохиов. Бичигч нь Өвөр монголын Сүнэд хошууны гавж Балдан болой” гэж төгсгөл үгээ бичиж зорилгоо тодорхойлсон байна.

“Рашааны хурим” Монгол анагаах ухааны эмчилгээний туршлагын хураангуй эмхтгэл юм. Бүтэн нэр нь “Эм заслын машид хураангуйлсан рашааны хурим хэмээх оршвой” гэдэг. Төвөдөөр “Дүдзи гадон” гэнэ. 1785 онд Ишбалжир зохиосон бөгөөд нийт 7 хуудас, 9000 үсэгтэй.

“Рашааны хурим” сударт эмч өвчнийг танин барих идээ ундаа буюу хоол хүнс, явдал мөр буюу амьдралын дадал, эм буюу эмийн эмчилгээ, засал буюу заслын эмчилгээг дурдсанаас гадна, эмч засч чадах өвчнийг таван аймагт хуваан тайлбарласан байна. Мөн тэрбээр судартаа дээрх эмчилгээг хийхийн өмнө үзэж шинжлэх нь чухлыг дурдан “өвчний архагшсан хэмжээг мэдэхэд ирсэн элчийг шинжлэх бөгөөд элч нь тойн, тарнич, эс бөгөөс өөр ямар хүн байсан ч бие гэм үгүй, хувцас сайтай, морь унаж ирсэн, инээмсэглэж баярласан царайтай, эмч лугаа уулзсан даруйд яруу сайхан үг өгүүлэх тэргүүтэн болвоос маш сайн. Түүнээс урваж хувцас муутай, эмэгтэй

хүн, бузар буртагтай, муухай нэртэй, мэс барьсан, илжиг, тэмээ, үхэр унасан эсвэл явган ирэх, гартаа таяг шийдэм барьсан, урамгүй, арван хар нүгэлээс аль нэгийг нь үйлдсэн, айж ичсэн, амьсгаа дээрдсэн, “аяа халаг” хэмээн дуу алдсан, уйлсан, гараар өвс мод хугалах буюу хайрга чулуу имрэх, өлзий бусыг үзүүлсэн тэргүүтэн ирвээс муу бөлгөө” хэмээн бичсэн нь эмч өвчтөний харилцаа, хандлага, холбоог чухлаар авч үзсэн нь харагдаж байна.

Ишбалжир өөрийн туршлагыг дүгнэн, монголын эртний уламжлалт эм эмнэлгийн хүйтэн халууны онолыг “Анагаах ухааны дөрвөн үндэс” дэхь халуун өвчнийг анагаах онол эмчилгээтэй уялдуулан “Дөрвөн рашаан” хэмээх зохиолдоо “шороо мэт хүнд-хүйтэн өвчин” гэсэн тусгай бүлгээр өгүүлж, хүйтэн, халууны онолыг улам системжилсэн байна. Бас “Рашааны хурим”-даа үндсэн зургаан өвчнийг анагаах тухай тусгай сэдвээр өгүүлж, онол эмчилгээг системжлэн хөгжүүлжээ.

Өвчнийг танин барих ёс буюу анагааж чадах өвчнийг 5 аймагт хуваасан байна. Үүнийг дэлгэрэнгүй дурдвал:

Нэгдүгээр аймагт хий, шар, бадган, цус, шар ус, хорхой зэрэг үндсэн 6 өвчин.

Хоёрдугаар аймагт халуун өвчин, хүйтэн өвчин, бөөлжих, суулгах, гэдэсний хатгалга, цанх, нян, халуун хүйтэн харилцан урвах, хий халуун хавсрах, халуун хүйтэн харшилдах зэрэг эрхэм 10 өвчин буй. (энд чухал болох арван өвчин гэж хэлсэн боловч, зөвхөн халуу хүйтэн хоёр өвчнийг танилцуулж, бусад найман өвчнийг сүүлчийн гурван аймагт танилцуулав) Энэхүү 2 аймагт ерөнхий 16 өвчин багтах бөгөөд ялгарлавал 101 өвчин болно.

Гуравдугаар аймагт эрэгтэй, эмэгтэй, нялхас, өтхөс нийт орших дотоод нөхцлөөс үүсэн 70 өвчин багтана.

Дөрөвдүгээр аймагт гадаад нөхцлөөр үүсэх гэнэтийн 19 өвчин багтана.

Тавдугаар аймагт нас чанарын шүтээнээр тус тус болох 12 өвчин багтах бөгөөд сүүлийн 3 аймаг нь ялгавартай 101 өвчин болно.

“Рашааны хурим” сударт буй өвчний ангилал, нэрс:

НЭГДҮГЭЭР АЙМАГ:

Хорлогч гэмд шүтсэн халууны хүрээнд хамаарах хүч ихтэй халуун өвчин:

1. Эс боловсорсон халуун /ᠡᠰᠪᠣᠯᠪᠰᠣᠷᠰᠣᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Боловсроогүй халууны шалтгаан нь бадган хий, нөхөд үл ялгаран өвчний хүч төгсөөгүй, эхийн адаг дуусаагүй тул боловсроогүй хэмээмэй.
2. Дэлгэрсэн халуун /ᠳᠡᠯᠭᠡᠷᠰᠡᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Дэлгэрсэн халууны шалтгаан нь хорлогч шар бөгөөд чанар халуун, хурц юм. Өвчин боловсорч хүч төгссөн ганц тэр халуунаар биеийн тамирыг шатаахын тул дэлгэрсэн хэмээмэй.
3. Хоосорсон халуун /ᠬᠣᠣᠰᠣᠷᠰᠣᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Хоосорсон халууны шалтгаан хий болой. Орноор хоосон нь гол судлын хийн оронд бууж, орны эрхээр халууныг хий тууж, тэр нөхцлөөр хий халуун харшлах өвчин болой. Хий нь хүйтэн чанарт сул халуун бэлгэ харшилна. Хоосон халуун нь тархан хүний нүүрсний гал мэт, хөөрөг хүйтэн боловч галын нөхөр болой. Дуугаа үл таслан халууныг улам их бадруулахын тул хоосон халуун хэмээн нэрлэхгүй.
4. Нуугдсан халуун /ᠨᠠᠭᠤᠭᠳᠰᠠᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Нуугдсан халууны шалтгаан нь хүйтэн хий болой. Халуун нуугдсан гал адил, хүйтэн хий хоёроор халууны эхийг бүрхсэнээр бадган хийн доор халуун бэлгэ далд болой.
5. Хуучирсан халуун /ᠬᠡᠭᠤᠴᠢᠷᠰᠠᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Хуучин халууны шалтгаан нь жил сар

болсон болой. Нөхцлөөр жил сар болтол өвчин тамир нийлэлэн шунаснаар төмөрт зэв мэт, бүсэнд тос мэт, модонд будаг нийлсэн мэт язгуураас гаргахуй бэрх, удсан тул хуучин халуун хэмээмэй.

6. Булингартсан халуун /ᠪᠤᠯᠢᠩᠭᠠᠷᠲᠰᠠᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Булингартсан халууны шалтгаан нь шар ус болой. Өөрийн чанар нь шар усны хүч их халуун зассаны сүүлд өвчний шүтээн дээр хүрх буй.
7. Тархсан халуун /ᠲᠠᠷᠬᠰᠠᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Тархсан халууны шалтгаан, өвчн ба бийн тамир мөн буюу. Биеийн тамир тархсанаар цус хямралдаж шар халуун болон хөдлөх, түүний тул тархсан халуун нэрлэхгүй.
8. Хямарсан халуун /ᠬᠢᠶᠠᠮᠠᠷᠰᠠᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Шалтгаан нь өөрийн чанар шарын халуун мөн буй. Биеийн тамирыг халуунаар түймэрдэхийн тул хямралдсан хэмээжээ.
9. Хижгийн халуун /ᠬᠢᠵᠢᠭᠢᠨᠬᠠᠯᠠᠭᠤᠨ/

Шалтгаан, нөхцөл тэднээр шөрын галын илчийг хөдөлгөөд хөлс буун бадган, шар, хийгээр зургаан орох үүдээр зэргээр орох ба үнэр хүрсэн гамшиг өвчин хижиг халдахын тул хижиг хэмээн нэрлэхгүй.
10. Бодо /ᠪᠣᠳᠣ/

Бодо нь ерийн халуунтай адилд чанар халуун шар усанд оршиж, яс чөмөгний язгуураас төрхүй болуу.
11. Гэдэсний хатгалга /ᠭᠡᠳᠡᠰᠡᠨᠢᠬᠠᠲᠭᠠᠯᠭ᠋᠎ᠠ/

Гэдэсний хатгалгын шалтгаан нь хижигийн халууны ерийнхтэй адил бөлгөө. Элэгний халуун уруу буусанд нян өвчин, шар ус, цөсний халуун хөдөлсөнөөр гэдэсний хатгуулан уруу суухүй гэдэсний хатгалга болой.
12. Сахуу /ᠰᠠᠬᠠᠭᠤ/

Шалтгаан нь цусны оронд хорт хорхой долоо буй. Зэс мэт улаан нарийн болоод үл үзэгдмэй. Нэг агшины төдийгөөр тэргүүн хөл түгээмэлд гүйн чадмэй.

13. Боом / *ᠪᠣᠮ* /

Сахуу, боом түүний шалтгаан нь цусанд оршигч долоон хорт хорхой. Зэс мэт улаан нарийн бөгөөд нүдэнд үл үзэгдэнэ. Хорхой хямарч биеийн тамирыг идсэнээр нянгийн өвчин болно.

14. Дагшуур / *ᠳᠠᠭᠰᠤᠭᠤᠷ* /

Шалтгаан нь ерийн хижиг мэт бөгөөтөл нөхцөл нь буртаг идээн, явдал идээн холилдсон, өлснийүнэр бузар туссан нөхцлөөс болсон буй.

Хүйтний хүрээнд хамаарах бодитой хүйтэн өвчин:

1. Эс шингэсэн / *ᠡᠰᠰᠢᠩᠭᠡᠰᠡᠩ* /

Эс шингэсэн өвчин бол дотор өвчин бүхний шалтгаан болох бөгөөд бэтэг, цайвар хаван, суваг хаван, усан хаван зэрэг 4 архгийн үндэс болно.

2. Галын илч буурсан / *ᠭᠠᠯᠠᠨᠢᠯᠠᠨᠢᠯᠠᠨᠴᠢᠪᠤᠷᠰᠠᠩ* /

Биеийн илч бууран, бүрэн бус шингэсэн идээний зүйлээр суулгах шинж тэмдэг бүхий бадган өвчний нэг зүйл болно.

3. Аюулхайн бадган / *ᠠᠶᠤᠯᠬᠠᠢᠨᠪᠠᠳᠭᠠᠨ* /

Аюулхайн доор бөөм юм цугларсан мэт санагдаж цүнхийж өвдөх онцлог шинж тэмдэг бүхий бадган өвчний нэг зүйл болно.

4. Төмөр хагт бадган / *ᠲᠥᠮᠥᠷᠬᠠᠭᠲᠤᠨᠪᠠᠳᠭᠠᠨ* /

Төмөр хагт бадган болбоос идсэнээ бөөлжмүй.

5. Хоолой хаагдах бадган / *ᠬᠣᠣᠯᠠᠢᠬᠠᠭᠠᠳᠠᠬᠤᠪᠠᠳᠭᠠᠨ* /

Хоолой хаагдах бадган болбоос залгуурт идээ үл ормуй.

6. Цагаан хэрх бадган / *ᠴᠠᠭᠠᠨᠬᠡᠷᠬᠤᠪᠠᠳᠭᠠᠨ* /

Шингээлт тэгш бус болж ходоод элгээр хавсран өвдөж, үе гишүү хэрж өвдөх шинж тэмдэг бүхий бадган өвчний нэг зүйл болно.

7. Шингээн хатаагч / *ᠰᠢᠩᠭᠡᠭᠡᠨᠬᠠᠲᠠᠭᠠᠭᠴᠢ* /

Шингээн хатаах бадган болбоос идэвч

цадхаа үл мэдэх, хэвлий нь томрох, шилбэ чичирч бие турмуй.

8. Бэтэг / *ᠪᠡᠳᠡᠭ* /

Биеийн ямар нэгэн оронд муу цус, шар ус зэрэг цугларч бэтгэширэн бүрэлдсэнийг хэлнэ. Бэтэг нь дотор хуйларч бөөгнөрснөөс үүснэ.

9. Цайвар хаван / *ᠴᠠᠶᠢᠪᠠᠷᠬᠠᠪᠠᠨ* /

Цайвар хаван, суваг хаван, усан хаван 3 болбоос ходоодны илч буурч шар ус дэлгэрсэнээс үүснэ. Биед усны хувь нэмэгдэн арьс махны нимгэн газраар сэлхрэх шинж тэмдгээр илрэх хаван өвчин.

10. Суваг хаван / *ᠰᠤᠪᠠᠭᠬᠠᠪᠠᠨ* /

Цайвар хаван хүндрээд усан хаван болж буй эмнэлзүйн шинж тэмдгийн үеийг хэлнэ.

11. Усан хаван / *ᠤᠰᠠᠨᠬᠠᠪᠠᠨ* /

Суваг хаван хүндэрч бадган салс арвидаж, уруу арилгагч хийн дотор гүйдэл сүвийг хаан услаг нь бүх биеийн тунгалаг тамирын гүйх сүвд алдагдах буюу эсвэл бөөрний усны үйл ажиллагаа доройтсоноос услаг нь хийгээр бүх биед сарниж үүснэ.

12. Барагдуулагч их архаг / *ᠪᠠᠷᠠᠭᠳᠤᠭᠤᠯᠠᠭᠠᠭᠢᠬᠡᠢᠬᠡᠠᠷᠬᠠᠭ* /

Баас шээс доод хий хаагдаж тунгалаг тэргүүтэн биеийн тамир тус барагдсан. Хатууг хүчилсэн, үл зохилдох идээ ундааг шүтсэнээр хий шар бадганыг гэм хямралдаж бүх биеэр түгж сүв хямралдан галын илч буурсанаар тунгалаг эс боловсрон хир болсноор биеийн тамирыг барагдуулах.

Хурмал өвчин дор:

1. Бадган бор / *ᠪᠠᠳᠭᠠᠨᠪᠣᠷ* /

Бор гэдэг бол өвчний мөн чанарын бүрэлдсэн онцлогоор нэрлэсэн ерөнхий нэр болно. Бас өөрөөр хурмал өвчин гэдэг. Тус өвчин бадган арвдан шартай хавсран хямралдаж хийтэй нийлээд муу цус, шар усыг үүсгэх буюу эсвэл бусад нөхцлөөр биеийг гэмтээж муу цус нь

элгэнд очиж тунгалаг эс шинэгэснээс шалтгаалж бор өвчнийг үүсгэх болно.

Товчилвол хорлогч гэм хий, шар, бадганд шүтэж болох халуун, хүйтэн өвчин 27, хорлогдогч махбодоос болох 30, халуун хүйтэн алинд нь ч хамаарахгүй хэсэг бусаг өвчин 13, нийт 101 өвчнийг бичиж ангилал, шинж, эм, засал, даруулга зэргийг дурдаж тэмдэглэсэн байна.

Хэлцэмж:

XVI зууны сүүл үеэс Аюурвед-ээс эхтэй анагаах ухааны ном судрыг орчуулах төдийгүй монголын эрдэмтэй лам эмч, оточ нар Энэтхэг, Төвөдийн эмнэлгийн ном зохиолыг өөрийн орны ахуй нөхцөл, уур амьсгал, орон нутгийнхаа эмт бодисын чанар байдалд нийцүүлэн монголын онцлогтой эм эмнэлэг, эмийн жорыг шинэчлэн боловсруулах ажлыг өөрийнхөө хөрсөнд буулгаж чадсанаар Монголын уламжлалт анагаах ухааны нэг шинэ салбар бүрэлдэн тогтсон ажээ. Үүний томоохон төлөөлөгч нь алдарт эрдэмтэн, эрдэнэ бандида Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) мөнөөсөө мөн билээ. Монголын XX зууны анхны ардын уран зохиолч, манлай соён гэгээрүүлэгч Ц.Дамдинсүрэн “Монголын уран зохиолын тойм” 1957 он бүтээлдээ арван наймдугаар зууны үед Хөх нуурт монгол эрдэмтэн Сумбо-хамбо гэгч (1704-1788) гарлаа. Түүний жинхэнэ нэр Иш-балжир гэдэг боловч Сумбо-хамбо гэж олонд алдаршжээ. Сумбо-хамбо уран зохиолын судлалыг хийж гарамгай зохиолыг бичжээ. Түвд монгол Гэсэрийн туужийг судалж, маш чухал хоёр саналыг хэлж өгсөн байна. Түүний нэг нь Гэсэр хааныг түүхт хүн гэж бичжээ хэмээн өгүүлээд түүнийг төвд хэлээр бүтээлээ туурвидаг монгол хүн болохыг тэмдэглэжээ.

Түүнийг ази, европын олон орны эрдэмтэн

мэргэд зуу гаруй жилийн турш судалж ирлээ. Тухайлбал италийн эрдэмтэн Жузеппе Туччи түүнийг “өргөн цар хүрээтэй нэвтэрхий толь” гэж нэрлэжээ. Сүмбэ хамба Ишбалжир бол бурхантын гүн ухааны түүх хийгээд гүн ухааны онолыг тайлбарлах, боловсруулахад хүчин зүтгэгч төдийгүй, ерөөсөө бурхны шашин төвт дорнын соёлын өв санг бүтээлчээр эзэмшин, монгол оронд дэлгэрүүлэх талаар томоохон үүрэг гүйцэтгэсэн соён гэгээрүүлэгч эрдэмтэн хүн болно хэмээн Д.Дагвадорж нарын “Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цоморлог” бүтээлд 1998 онд тэмдэглэжээ.

Тэрээр угсаатны ба домог зүйч, их ажигч эрдэмтэн төдийгүй буддын гүн ухаан, зурхай судлал, одон орон судлал, монголын эртний яруу найргийн томоохон төлөөлөл болж өөрийн эрдэм мэдлэг, авьяасаа эрдэм бүтээлдээ шингээжээ.

“Анагаах ухааны талаар Ишбалжирын туурвисан цуврал таван ном байгаа нь монголын анагаах ухааны түүхнээ мөнхөрсөн зохиолуудын дотроос хамгийн цэгцтэй, иж бүрэн зохиол болно” Г.Жамсран “Сэтгэл булаагчид” төвд хэлт монгол утга зохиолын зарим оддын тухай, 1998 он.

Тухайлбал “Монгол оронд хүйтэн өвчин элбэг тохиолддог бөгөөд түүнийг нь халуун эмчилгээний арга, төөнөөр засдаг талаар одоогоос 2000 гаруй жилийн өмнө бичигдсэн “Хуанди Нейжин” зохиолд тодорхой дурдсан байдаг. Хөх нуурын эрдэмтэн Сүмбэ хамба Ишбалжир “Рашааны хурим” зохиолдоо хүйтэн өвчний талаарх төлөв байдлаас авхуулаад шалтгаан үр үүсэх нөхцөл, ерөнхий ба ялгавартай шинж тэмдэг, судас шээсний оношилгоо ба хүйтэн өвчний олон төрөл зүйлийн ангилал, махбод хямралдах явц, хорлох ба туслах идээ, явдал мөр, эм засал зэргийг цогц байдлаар тодорхойлсон байдаг”

хэмээн “Увдисын үндэс дэх бөөрний үндсэн өвчнүүдийн шинжийг эдүгээчлэн харьцуулах нь” 2020 он, Э.Бат-Эрдэнэ анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээлд өгүүлжээ.

Дүгнэлт:

Эрдэнэ бандида Сүмбэ хамба Ишбалжир бол дээд Монголын хүн, арван хоёрдугаар жарны хөхбичинжил (1704 он, Энхамгалангийн 43 дугаар он)-ийн билгийн улирлын найман сарын арван тавны өглөө луу цагт одооны Хөхнуур мужийн толь гацаанд Батуд овгийн тайж Дорждашийн дөрөвдүгээр хөвгүүн болон заяажээ. Сүмбэ хамба Ишбалжир 1785 онд “Рашааны хурим” судрыг төвөд хэлээр бичсэн бөгөөд Монгол анагаах ухааны эмчилгээний туршлагын хураангуй эмхтгэл юм. Бүтэн нэр нь “Эм заслын машид хураангуйлсан рашааны хурим хэмээх оршвой” гэдэг. Төвөдөөр “Дүдзи гадон” гэнэ. Нийт 7 хуудас, 9000 үсэгтэй. “Рашааны хурим” сударт эмч өвчнийг танин барих идээ ундаа буюу хоол хүнс, явдал мөр буюу амьдралын дадал, эм буюу эмийн эмчилгээ, засал буюу заслын эмчилгээг дурдсанаас гадна, эмч засч чадах өвчнийг таван аймагт хуваан тайлбарласан байна.

Ном зүй:

1. Анагаах ухааны дөрвөн үндэс. Язгуурын үндэс ба Номлолын үндэс (төвөд монгол, англи, орос хэлээр) УБ, 2001.
2. Болд Ш., Б.Жавхлан., “Хүннүгээс XXI зууны Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш, бариач нарын цадиг, бүтээлийн ойллого” УБ, 2016
3. Болд.Ш. Монголын анагаах ухааны түүх. Дөрөвдүгээр боть. УБ, 2013
4. བུད་མྱེད་པོ་ཡན་ལག་བརྒྱན་བ་གསང་བ་མན་ངག་གི་རྩད་བཞགས་སྟེ། **МОДОН**
барын төвөд, монгол судар

5. བུད་མྱེད་པོ་ཡན་ལག་བརྒྱན་བ་གསང་བ་མན་ངག་གི་རྩད་བཞགས་སྟེ། **Модон барын төвөд судар**
6. བུད་མྱེད་པོ་ཡན་ལག་བརྒྱན་བ་གསང་བ་མན་ངག་གི་རྩད་བཞགས་སྟེ། **Модон барын төвөд судар**
7. བུད་མྱེད་པོ་ཡན་ལག་བརྒྱན་བ་གསང་བ་མན་ངག་གི་རྩད་བཞགས་སྟེ། **Модон барын төвөд судар**
8. བུད་མྱེད་པོ་ཡན་ལག་བརྒྱན་བ་གསང་བ་མན་ངག་གི་རྩད་བཞགས་སྟེ། **Модон барын төвөд судар**
9. Сүмбэ хамба Ишбалжир. Дөрвөн рашаан. Хөх хот, ӨМАХХ, 1998, х.109-112, 324-339, 340-352, 395-397
10. Ц.Дамдинсүрэн., Монголын уран зохиолын тойм. УБ, 1957 он, 16.
11. Д.Дагвадорж., Монголын гүн ухааны мэргэдийн зохиолын цомирлог, УБ, 1998 он, 84.
12. Г.Жамсран., Сэтгэл булаагчид. Төвд хэлт монгол утга зохиолын зарим оддын тухай, УБ, 1998 он, 27-28.
13. Э.Бат-Эрдэнэ., Увдисын үндэс дэх бөөрний үндсэн өвчнүүдийн шинжийг эдүгээчлэн харьцуулах нь. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл., УБ хот, 2020 он, 53.

*Уншин танилцсаж, нийлтэх санал өгсөн:
АУ-ы доктор, дэд профессор Х.Туул*